

МОНГОЛ ДАХЬ ХЯТАДЫН ФИЛОСОФИЙН СУДАЛГАА: ҮР ДҮН, АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

М.Золзаяа
ШУА-ийн Философийн хүрээлэн,
доктор (PhD)

Товч агуулга: XVII зууны үеэс өрнө дахины бүтээлүүдэд Хятадын философи 中国哲学 хэмээх нэршил хэрэглэгдсэн. Хятад болон өрнийн философичдын бүтээлд “Хятадын философи” гэж байна, байхгүйн тухай үндэслэлүүдийг дэвшүүлсэн байдаг. Гэхдээ олон улсад түгээмэл хэрэглэгддэг философийн нэвтэрхий толь бичгүүдэд “Хятадын философи” гэдэг ойлголт хэвшин тогтоож, Күнз, Мэнз, Жуанз, Ху Ши нарын үзэл санааг тайлбарласан буй. Илтгэлд манай оронд Хятадын философи хэрхэн судлагдсаныг тоймлон, судалгааны арга зүйн талаар зарим саналыг дэвшүүлэв.

Түлхүүр үг: Хятадын философи, ёс зүй, даосизм, марксизм, хятадын уламжлалт соёл

Юуны өмнө Хятадын философи судлагдсан байдлыг тоймлоход дорно дахины орнуудын утга, соёлын харилцаа холбоо, оюун санааны амьдралд гарсан өөрчлөлт, үзэл суртлын хандлагыг харгалзсан болно.

Манайд философийн сургалт, судалгааны байгууллага албан ёсоор үүсэж хөгжсөн үеэс 1990-ээд он хүртэл өгүүлэн буй сэдвээр тусгайлсан судалгаа хийгдээгүй бөгөөд санал, санаачилга төдийлөн гараагүй гэж болно. 1990 оноос өмнө марксист философичдын анхаарал татсан нэг сэдэв бол хувьсгалч, коммунист удирдагч, улс төрийн онолч Мао Зэдуны үзэл суртал байсан юм. Мао Зэдуны улс төрийн үзэл санаа, стратегийг философийн багш судлаачид шүүмжилж, товхимол, нийтлэл хэвлүүлж байжээ. Тухайлбал, 1959 онд С.Норовсамбуу Монгол-Хятадын найрамдлын 15 хоногт зориулан “Мао Цзе Дун бол марксизм ленинизмийг Хятадын хувьсгал ба социалист байгуулалттай бүтээлчээр холбон хөгжүүлэгч мөн” (Ред. Ч.Далай) товхимлыг хэвлүүлжээ.

МАХН-ын Төв хорооны дэргэдэх Намын түүхийн институт, Болгарын ШУА-ийн Орчин үеийн нийгмийн онолын хүрээлэн, Унгарын Олон улсын харилцааны хүрээлэн, Польш, Чехийн КН-ын Төв хорооны дэргэдэх Марксизм-ленинизмийн хүрээлэн, ЗХУ-ын ШУА-ийн Алс дорнодын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд санал солилцох замаар нэгтгэн дүгнэсэн материалыг 1974 онд “Маоизм бол марксизм-ленинизмийн үзэл санаа, улс төрийн дайсан мөн”

нэрээр хэвлүүлжээ. Энэ товхимолд “Хятадад 毛主席 -маоизм гэсэн нэр томъёог хэрэглэхийг цээрлэдэг, 毛泽东思想 -Мао Зэдуны үзэл санаа гэсэн үгийг гадаад хэлэнд “маоцзедунч үзэл” гэсэн санаагаар орчуулжээ”¹ хэмээсэн. Мөн Мао Зэдуны 1953 оны түүвэр зохиолын 2 дугаар ботиос “Түүхэнд марксист ёсоор хандагчид бид өнгөрсөн үеийнхээ түүхийг үл ойшоон огоорч болохгүй. Бид Күнзээс аваад Сун Ятсенийг хүртэлх манай бүх өнгөрсөн үеийг нэгтгэн дүгнэж, тэр үнэт зүйлийг эзэмших ёстой. Энэ нь одоогийн аугаа их хөдөлгөөнийг удирдахад ихээхэн түшиц болж өгнө...”² гэснийг эш татаад Хятад уламжлалт философио хадгалж буйг шүүмжилж, марксизм ленинизмийг завшин ашиглаж байна гэж дүгнэжээ. Зохиогчид төрийн сонин хэвлэл, Маогийн түүвэр зохиол, ХКН-ын баримт бичиг зэргээс эшлэсэн байна. Мөн легизм, даосизмын (Daoism) талаар товч тайлбар зүүлт хийжээ. ФСЭХ-ээс Д.Дашжамц, Г.Лхагвасүрэн нар³ сонинд шүүмжлэлт нийтлэл хэвлүүлжээ. Академич Н.Ишжамц “Күнзийн хятад төвийн үзэл /синоцентризм/ маоизмд хүчтэй нөлөөлснийг маоист ном зохиол нотолсоор байна”⁴ зэргээр бичжээ. Эдгээр нь маоизмыг шүүмжилж марксизмыг хамгаалах зорилт тавьжээ.

Эдүгээ “Мао Зэдун Хятадын онцлогтой нөхцөл байдлыг бодитоор харж, ажилчин ангиар тэргүүлсэн аж ахуйтны өвөрмөц замыг нээсэн, өрнө дорныг харьцуулж, өнгөрсөн ба эдүгээгийн зохицол дээр шинэ ардчилсан үзлийг бий болгосон. Хятадад марксизмыг нутагшуулж, Хятадын бодит нөхцөлд марксизмыг бүтээлчээр ашиглаж, орчин үежих түүхэн асуудлыг амжилттай шийдвэрлэсэн бөгөөд эртний үндэстнийг орчин үе рүү шилжих түүхэн зорилгыг эрчимжүүлж, онол практикийн түвшинд гайхалтай амжилтад хүрсэн”⁵ гэж үнэлж байна. Мөн КН-ын амжилт нь Хятадын соёлын мөн чанарыг марксизмтай хослуулсан, нөгөө талаар Мао Зэдуны “ард түмний төлөө” гэсэн уриа нь ард түмэн түүхийг бүтээнэ гэсэн Марксын материалист үзэл ба ард түмэн төрийн үндэс, түүний хамгийн чухал бүрэлдэхүүн гэсэн уламжлалт үзэлд үндэслэсэн юм... гэхийн зэрэгцээ “Мао Зэдун модернизацийн зөв замыг сонгоогүй, ХКН хүссэн амжилтдаа хүрээгүй шалтгаан нь түүний субъективизм болон ард түмний хүсэл бүхнийг тодорхойлно хэмээсэнд оршино”⁶ гэсэн дүгнэлт ч байна.

Зөвлөлтийн философи Хятадад хэрхэн нөлөөлсөн талаар Хятадын профессор Ань Цинянь “Орост зөвлөлтийн философи түүх болж үлдэв. Харин Хятадад энэ философи чухамдаа үргэлжилсээр байна... Хэрэв эдүгээгийн байр сууринаас үзвэл, зөвлөлтийн философи хүн төрөлхтний социаль харилцааны түүхэнд, философи сэтгэлгээний түүхэнд, Орос, Хятадын агаад бусад социалист орнуудын соёлд

1 Маоизм бол марксизм-ленинизмийн үзэл санаа, улс төрийн дайсан мөн. УБ., 1974. 3 дахь тал.

2 Мөн тэнд. 3 дахь тал.

3 Дашжамц Д., Лхагвасүрэн Г. Маоизмын нуруулт. Үнэн сонин. 1980 он.

4 Ишжамц Н. Түүхийг гуйвуулах маоист аргыг шүүмжлэх нь. УБ.,1981. –Академич Н.Ишжамцын бүтээл туурвил. Тэргүүн дэвтэр. УБ.,2010. 277-295 дахь тал.

5 Han Zhen and Zhang Weiwen. China's Values. 北京: 中国社会科学出版社., 2018. p.137.

6 Wang Meng. The Chinese way of thinking. Beijing, Foreign Languages Press., 2018. pp. 135, 145.

томоохон нөлөө үзүүлсэн”¹ хэмээн дүгнэжээ.

Социализмын үед Күнзийн сургаалаас огт дурдахгүй байсан хэрэг биш. Г.Гонгоржав, С.Жамбалдорж нарын 1967 оны “Мэргэдийн мянган сургаал” эмхэтгэлд Күнз “Тус болох нөхөр гурав, ус болох нөхөр гурав болой. Тус болох нөхөр - шулуун нөхөр, шударга нөхөр, ихийг дуулсан нөхөр болно. Ус болох нөхөр - нүүр тал засагч нөхөр, зусар бялдууч нөхөр, цууранхай амт нөхөр болно” хэмээн сургасан гэж оруулжээ. Д.Дашжамц 1968 онд “монголчууд бусад орны ёс суртахууны холбогдолтой судар зохиолыг орчуулан ашиглаж байсан нь бас их. Хятадын Күнзийн сургаал ном, Энэтхэгийн “Панчатантра”, “Ардыг тэжээхүй рашааны дусал”, Түвдийн “Эрдэнийн сан Субашид” зэрэг олон сайхан зохиолыг орчуулан үзэж байжээ”² хэмээгээд Күнзийн сургаалаас эшилсэн буй.

1990-ээд оноос нийгэм, хүмүүнлэгийн салбарын эрдэмтдийн бүтээлд Хятадын философийг авч үзэх хандлагад өөрчлөлт гарсан. Академич Н.Ишжамц “БНХАУ-ын түүхийн товч тойм” бүтээлдээ “даосын ёс, цааз хуулийн номлол, ялангуяа Күнзийн суртал нь боол эзэмших ёсны дараах, феодалын хятадын улс төр, эдийн засаг, соёлын бүх салбарт гүн гүнзгий нөлөө үзүүлсэн байна. Тийм ч учраас түүхийн чухал сурвалж болдог. Түүнээс гадна Күнзийн бичсэн “Цюньцю /Хавар, намар/” зохиол эртний Хятадын вант улсуудын нэгэн болох Лу улсын түүх учир нэн чухал сурвалж мөн. Күнзийн зохиолуудад төр засаг, ёс суртахууны номлол голлох боловч хятад төвийн үзлийн зүйл орсон нь Хятадын дараа дараагийн төрийн эрх баригчдын бодлого, үзэл сурталд гүнзгий нөлөөлсөн талтай” хэмээжээ. Тэрээр даосын ёс, цааз хуулийн номлол, Күнзийн суртал гэсэн томъёолол хэрэглэсэн байгаа юм.

Судалгааны явцад “Философи, эрхийн судлал” сэтгүүлийн хэвлэгдээгүй дугаарын эхээс Т.Эрдэнэбилэгийн (1996-2000 онд УИХ-ын гишүүн асан) 1990 онд бичсэн “Күнзийн сургаал дахь хүний эрмэлзэх эрхэм дээд чанар” гэсэн өгүүлэлтэй³ танилцав. Хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөс хэвлүүлэх шийдвэр гарсан ч санхүүгийн боломжгүйгээс сэтгүүл хэвлэгдээгүй байна. Зохиогч хувийн цуглуулга болох “Дөрвөн бичиг” хятад-манж-монгол хадмал судар дахь “Шүүмжлэл өгүүлэл” зохиолыг ашиглаж, тодорхой хэсгийг нь хөрвүүлэн хавсаргажээ. Үүнд:

“Эл үзэл сургаалыг бүхэл бүтэн өвөрмөц гүн ухаан гэж хэлбэл болох боловч ихэнх нанхидагч эрдэмтэд үүнийг улс төр-ёс суртахууны сургаал гэж нэрийдэх нь илүүтэй билээ... Күнз дундыг чанд барь гэх зэргээр сургасан нь Энэтхэгийн суут ухаантан Нагаржунагийн дундад үзлийн философийг санагдуулна. ...Юмс үзэгдлийн шулуун ба утгын харьцааг тэнцүүлэхийн чухлыг заан тэмдэглэж бидний одоогийн ухагдахуун ойлголтоор цэгнэвэл мөн чанар буюу агуулга

1 *Ань Цинянь. Зөвлөлтийн философийг хятад эрдэмтэн үзэхүй нь.* //Философи, эрхийн судлал. Боть 34. УБ., 2019. 264 дэх тал.

2 Дашжамц Д. Монголын ард түмний ёс суртахууны дэвшилт өв уламжлалаас. УБ.,1968. 16 дахь тал.

3 Философи, эрхийн судлал. XIV ботгийн эх, 1990 он. ШУА-ийн Философийн хүрээлэнгийн номын сан.

ба өнгөн илрэл буюу хэлбэрийг тусгайлан салгалгүй гагцхүү нэгдэл холбоонд нь авч үзсэнээр гэнэн хэдий авч диалектикийн үүсвэр бүхий сэтгэлгээ илрэх авай. Күнзийн сургаал бүхэлдээ тодорхой хувь хүнд хандаж, юуны түрүүнд бие хүний хүчин зүйлийг дээдлэн өргөмжлөхийг эрэлхийлсэн оролдлого байжээ... Эл утгаар задлан авч үзэхүл Күнзийн үндэслэсэн үзэл онол мөн чанартаа хүний нийгэмчлэгдэх ба нийгмийн хүмүүнчлэгдэх хоёр хандлагын хооронд тэгшитгэлийн тэмдэг тавьж чадсан Азийн нэн эртний соёл иргэншлээс язгуур үүсвэртэй түүхэн асар их үнэ цэн бүхий сонгодог жишээ болой”¹ зэргээр бичсэн байна.

1990-ээд оны дунд үеэс эхлэн МУИС-ийн багш нар Хятадын философийн талаар өгүүлэл хэвлүүлж эхэлсэн байна. Эдгээр судалгааны өгүүлэлд эртний эх зохиолууд дахь философийн ойлголт, сэтгэгчдийн намтар болон гүн ухаан, улс төр, ёс суртахууны үзэл сургаалын онцлог, тэдгээрийн өнөөгийн ач холбогдлыг тайлбарлажээ.

Хятадын философийн судалгаанд профессор Р.Дарьхүү чухал хувь нэмэр оруулж байна. Тэрээр “Өрнө, дорнын философи дахь хүний асуудал” эрдмийн зэрэг горилсон бүтээл (1996) болон бусад бүтээлдээ эртнээс орчин үе хүртэлх философийн чиглэлүүд, “инь ба ян”, “у-син”, “ци”, “дао”, “ли” хэмээх ойлголтууд,² “Их суртахуй” зохиол дахь гурван мөрдлөг, найман зорилго хэмээх ойлголтуудын утга санаа,³ Хятадын сонгодог философи дахь улс төр ба хүн, ёс суртахууны харилцаа холбоо, хүний эрх чөлөөний асуудал, Күнзийн ёс суртахууны болон хүний тухай сургаал⁴-ын талаар орос, англи, монгол ном бүтээлээс судлан бичжээ.

1 Философи, эрхийн судлал. XIV ботгийн эх, 1990 он. ШУА-ийн Философийн хүрээлэнгийн номын сан. 34-39 дэх тал.

2 Дарьхүү Р. *Эртний Хятадын философийн “инь ба ян”, “у-син”, “ци”, “дао”, “ли” хэмээх ойлголтууд.* //МУИС, Нийгмийн ухааны факультет. Эрдэм шинжилгээний бичиг. УБ., 1998. №4 (133).

3 Дарьхүү Р., Ундармаа Г. *“Их суртахуй” зохиолын агуулга ба орчин үе.* //Философи, шашин судлал. УБ., 2012. №371 (65). 32 дахь тал.

4 *Хятадын сонгодог философи дахь улс төрийн асуудал ба хүн, ёс суртахууны асуудлын харилцаа холбоо.* //Эрх чөлөө ба философи. УБ., 2000. №7., *Хятадын философи дахь хүний эрх чөлөөний асуудал.* -Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө. УБ., 2004, Дарьхүү Р., Бат-Эрдэнэ Г. *Хятадын философийн орчин үеийн үндсэн чиглэлүүд.* //Философи, шашин судлал. УБ., 2006. №263., *Хан улсын үеийн Хятадын философийн онцлог.* //Философи, шашин судлал. УБ., 2006. №235 (30). *Хятадын шинэ үеийн философийн онцлог.* //Философи, шашин судлал. УБ., 2007. №288 (41)., *Хубилай хааны улс төрийн үзэл ба Күнзийн сургаал.* //Лам нарын сэтгүүл. 2010 он. 7 сар. №2., *Ёс суртахууны талаарх Күнзийн сургаал ба орчин үе.* //Монголын Хятад судлал. Сэтгүүл. УБ., 2013, *Хүний тухай Күнзийн сургаал ба орчин үе.* //Монголын Хятад судлал. Сэтгүүл. УБ., 2014.

Олон оронд Хятадын философийг судалдаг эрдэмтэд нь философийн тэнхим, хүрээлэнд биш, шашин судлал, антропологи, хятад судлал, эртний судлалын салбарт харьяалагдах нь түгээмэл. Энэ хандлага манайд ч бий бөгөөд хятад судлаачид эх зохиол орчуулах, философийн гол ойлголтуудын утга санааг тайлбарлах судалгааг хийжээ. Профессор М.Чимэдцэеэ Лаозын “Даодэжин” буюу жам ёсны сургаал, хүн болохуйн ухааны сургаал Күнзийн сэтгэлгээ, соёлын уг сурвалжийг “Шүүмжлэл өгүүлэл”, “Их суртахуй”, “Хэв дундын ёс”¹ хэмээх гол бүтээлүүдийн агуулгаар үндэслэн, жишээ баримтаар баяжуулжээ.

Доктор Ч.Таамаа “Философи, шашин судлал” сэтгүүлд 2006 оноос хойш “Жуанз”, “Хятадын шашин шүтлэг хийгээд Күнзийн суртал”, “Эртний Хятадын буддын шашин ба хаант төрийн харилцаа”, “Хуулийн сургаалтны үзэл, түүний онцлог”² зэрэг эртний сэтгэгчдийн намтар, үзэл санааг тодруулсан өгүүлэл нийтлүүлжээ. Мөн тэрээр Г.Наранцэцэгтэй хамтран Шүнз, Сүнз, Ху Ши нарын намтар, үзэл санааг авч үзсэн байна. Миний бие 2007 онд “Ачлалт ном” хэмээх ёс суртахууны сургаалын тухай” хэмээх өгүүлэл бичсэн.³ Мөн М.Байгалмаа,⁴ доктор Б.Дэлгэрмаа,⁵ Д.Октябрь,⁶ Б.Мөнхцацралт⁷ нарын өгүүлэл хэвлэгджээ. Хятадын цөөн судлаач өгүүлэл, илтгэлээ манайд хэвлүүлжээ.⁸

Профессор Ц.Гомбосүрэн Күнз, Шүнз (298-238), Мо Ди, Лаоз, Мэнз нарын онтологи баримтлалд тэнгэрийн тухай сургаал, ахуй ба ахуй биш дао, инь янын сургаал, ертөнцийн үүсэл, оршихуйн талаарх таван махбодын сургаал олон ургалч байрнаас илэрхийлсэн⁹ гэжээ.

Доктор Г.Цэнд-Аюуш улс төрийн ухамсрын талаар хийсэн судалгаанд “Күнзийн эрхэм хүн, дундаж хүн, өчүүхэн хүн ангилал нь орчин цагийн нийгмийн дээд, дунд, доод хэмээх гурван давхраанд хуваан үздэг давхраажлын онолтой дүйж байгаа бөгөөд тэдгээрийн үүрэг, хариуцлагаа ухамсарлахыг өгүүлжээ”¹⁰ гэсэн байна. Монголчуудын тэнгэр шүтлэгийн тухай судалгаанд эртний

1 Чимэдцэеэ М. Бидний мэдэх хийгээд эс мэдэх Хятад орон: сэтгэлгээ соёл. УБ., 2012.

2 Философи, шашин судлал. УБ., 2006. №235 (30) зэрэг дугаарт үзнэ үү.

3 Золзаяа М. “Ачлалт ном” хэмээх ёс суртахууны сургаалын тухай. //Философи, шашин судлал. УБ., 2007. №277 (38).

4 Байгальмаа М. Эртний Хятадын сэтгэгч Мо-Ди, түүний нийгэм-ёс зүйн үзэл баримтлал. //МУИС. Эрдэм шинжилгээний бичиг. УБ., 1998. №4 (133).

5 Хятадын урлаг, утга зохиол дахь философи үзэл санаа. //Монголын Хятад судлал. Эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2013.

6 XIX зууны Хятадын улс төрийн философийн зарим чухал асуудал. //Олон улс судлалын дээд сургууль, Эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2009. №1.

7 Мөнхцацралт Б. Хятадын их сэтгэгч Лаозын “Дао-дө-жин” зохиол дахь үлэмж хүний тухай үзэл. //Философи, эрхийн судлал. Боть 34. УБ., 2019.

8 Mu liangZhang. The Cultural foundation of the intrinsic unification of Daoism and Confucianism. // Философи, шашин судлал. №17 /434/. 19-24 дэх тал.

9 Эртний Хятадын философи дэг сургуулиуд дахь онтологи үзэл. -1990-ээд оноос хойших Монголын философийн амьдрал. Эмх. Гомбосүрэн Ц. УБ., 2019. 29 дэх тал.

10 Цэнд-Аюуш Г. Улс төрийн ухамсар: түүхэн судалгаа. УБ., 2012. 144 дэх тал.

Хятадын тэнгэрийн ёсны тухай ойлголттой харьцуулсан зүйлс бий.¹ Энэчлэн манай эрдэмтэн судлаачид өөрийн үзэл, өнцгөөс харсан тайлбар, дүгнэлтийг дэвшүүлжээ.

Хятадын философийн онцлог ба түүнд хандах арга замын талаар судлаачдын байр суурь янз бүр. В.Инжиннаш бурхан багшийн номын сургаал, Күнзийн бичгийн сургаалын ялгааг тодорхойлж, “...цөм сайн хэрэг атал тэнцүүлэн нийгэмлэж эс чадагчид, нэгийг үзвээс нэгийг орхиж, гэм гаргахуйд хүрүүлж, ертөнцийн эрхийг алдаж осолдохын тул буй”² хэмээсэн нь аль нэг үзэл сургаалд авах гээхийн ухаанаар хандахыг сануулсан хэрэг. Академич Г.Лувсанцэрэн “Күнзийн сургаал нь өршөөл, журам, ёслол, мэргэн, бат гэсэн үндсэн зарчмуудад тулгуурладаг... Күнзийн төр-ёс зүйн номлол, Нагаржунагийн хоосон чанарын онол хоёр үлэмж ялгаатай, хоёр өөр эрэмбийн сургаалууд болох нь эл наад захын тоймоос ч тодорхой харагдаж байна. Эртний мэргэн Күнзийн сургаалд олон зууныг дамжин их Хятадын ард түмний төр ёс, зан суртахууны нөлөөлөл хадгалагдсаар ирсэн буй заа. Монгол орон Чин улсын эрхшээлд байсан үед Күнзийн суртлыг ялангуяа төрийн шугамаар нэвтрүүлэх бодлого явж байсан нь илэрхий. Харин Монголын ард түмэн Энэтхэгийн соёлын нэгэн хэсэг-буддын шашинд орсноор хятад-манжийн соёл иргэншлийн уусгах нөлөөллийг хааж чадсан юм гэж монголч эрдэмтэд нотолдог билээ”³ хэмээсэн юм.

Философи, ёс зүйн сурах бичгүүдэд Хятадын философийн талаар бүлэг, зүйлийн хэмжээнд бичигдсэн. Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр нарын “Философийн түүх” гэсэн 4 удаа хэвлэгдсэн сурах бичигт эртний Хятадын домгийн сэтгэлгээнээс Сун Ятсений үзэл (1866-1925) хүртэл гол төлөөлөгчдийн үзэл санаа (Хүснэгт 1.), ойлголтуудыг тайлбарласан. Зохиогчид орос, англи хэл дээрх номыг голлон эшилж, Фэн Ю Ланийн “Хятадын философийн товч түүх” (орч. Ү.Нямдорж, 2003), Жан Ши Чин “Орчин үеийн Хятад дахь Күнзийн сургаалийн хувь тавилан” (2016), “История китайской философии” (1989), Мел Томпсон “Восточная философия” (2000), “Encyclopedia of Chinese Philosophy” (Routledge, 2003), Karyn Lai “Introduction to Chinese Philosophy” (Cambridge University 2008) зэрэг англи, орос, монгол хэлээр хэвлэгдсэн сурах бичиг, толь бичгийг унших номын жагсаалтад оруулжээ.

1 Ачиймаа Н. Монголчууд ба хятадуудын тэнгэрийн тухай үзлийн нэгэн ялгааны тухай. // Дорно дахины гүн ухааны сэтгэлгээ ба орчин үе. Дорно дахины гүн ухааны дээд сургуулийн ЭШБ. УБ., 1999. 27 дахь тал.

2 Инжиннаши В. Хөх судар. I боть. УБ., 2009. 29 дэх тал.

3 Төв үзлийг тулгуурлахуйд. //Лувсанцэрэн Г. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас. УБ., 2008. 265 дахь тал.

Хүснэгт 1. “Философийн түүх” сурах бичиг дэх
“Хятадын философи” бүлгийн агуулга

Үе шат	Үзэл санаа, төлөөлөгчид
Эртний үеийн Хятадын философи	Хятад дахь домгийн философи, Инь Ян философи, Күнзийн философи, Мэнз, Шүнз (орос эхэд Сюнь-цзы гэнэ), даосизм, Жуанзын философи, моизм, легизм, нэрийн дэг, Хуй Ши-гийн философи
Дундад зууны Хятадын философи	Хан үеийн философи, неодаосизм (Ван Би), Күнзийн шинэтгэсэн сургаал (Жан Зай, Чэн Хао, Чэн И, Жу Си, Ван Ян Мин), чань буддизм (Хуй Нэн).
Шинэ үеийн Хятадын философи	Гун Зы Жэн, Хун Сю Цюань, Кан Ювэй, Янь Фу, Сун Ятсен

Доктор Ц.Гомбосүрэн “Философи” (2020), Ш.Ганхуяг, М.Гантуяа нарын “Философийн түүхэн тойм” (2002), Д.Тунгалаг “Ёс зүй” (2013), М.Золзаяа “Ёс зүй” (2014) сурах бичигт Хятадын философи, ёс зүйн талаар товч авч үзжээ.

XX зууны эхэн үеийн монгол сэтгэгчдийн зарим сургаалын зохиолд Хятадын ёс зүйн сургаал дахь гол ойлголт, хэллэгийг ашигласан, мөр, шадаар эшилсэн нь цөөнгүй тохиолддог. Энэ нь эртнээс улбаатай ажээ. НТӨ 200-аад оны үеийн “Ачлалт ном-孝经” 1307 онд Юань гүрний үеийн Төв бичгийн яамны Баруун гарын тэргүүн сайд Бултөмөр монгол хэлээр орчуулж, улсын дөрвөлжин бичгээр хэвлэсэн гэдэг. 480 онд Монгол, Сяньби аймгийн мэргэн гүүш нар Ачлалт номыг монгол хэлнээ орчуулсан, XIX-XX зууны үед Өвөр Монголд дөрвөн удаа орчуулагдсан¹ тухай эрдэмтэн Х.Лувсанбалдан 1961 оны эрдэм шинжилгээний латин галигт буулгасан хэвлэлдээ тэмдэглэжээ.

Сүүлийн жилүүдэд хятад, англи, орос хэл дээрх эхүүдийг ашигласан орчуулга, хөрвүүлгийн бүтээлүүд гарсан. Ү.Нямдорж 1934 онд англи хэлээр хэвлэгдсэн нэрт философич Фэн Ю Ланийн “Хятадын философийн товч түүх” номыг 1998 онд орос хэлнээс орчуулсан нь ач холбогдолтой болсон юм.

2004 онд “Шүүмжлэл өгүүлэл” зохиолыг хятад судлаач М.Чимидцэеэ орчуулсан. Тэрээр мөн 2013 онд МУИС-ийн Күнзийн Институтээс “Шүүмжлэл өгүүлэл”,² Зэнзийн “Их суртахуй”, Зы Сигийн “Хэв дундын ёсон”, Сүнзийн “Дайтахуйн ухаан” гэсэн дөрвөн сонгодог зохиолыг монголоор орчуулсан. Тэдгээр сонгодог бүтээлийг орчуулсан нь эртний Хятадын сэтгэгчдийн сургаалтай танилцах боломжийг олгосон.

1 Лувсанбалдан Х. Ачлалт номын тухай. Studia Mongolica. Tomus III. УБ., 1961. 36 дахь тал.

2 Күнз. Шүүмжлэл өгүүлэл. Орч. Чимэдцэеэ М. Монголд анх удаа бүрэн эхээрээ 5 дахь хэвлэл. УБ.; Адмон, 2013.

Профессор Б.Даш-Ёндон 2014 онд Орос, Хятадад В.П.Бутромеевийн эмхэтгэн хэвлүүлсэн “Конфуций: Афоризмы мудрости” номон дахь П.С.Попов,¹ В.П.Васильев нарын орчуулгыг сонгон товч тайлбарын хамт хэвлүүлсэн юм. Номын нэрийн хувьд орос хэлнээс “Лунь-юй-Бодрол агаад яриа” хэмээн орчуулжээ.

Зохиолч Г.Аюурзана 2002 онд Кониси Масутора, Ян Хиншун нарын орос хэл дээрх орчуулгаас харьцуулан “Дао: амьдралыг танихуй” хэмээх нэрээр хэвлүүлсэн. 2004 онд Бээжин Их сургуульд сурч байсан Д.Наранжаргал Лаозын “Дао дө зин”-г хятад эх, орос, англи хэлэнд хөрвүүлэгдсэн орчуулгуудтай харьцуулан орчуулж,² 2005 онд физикч Ж.Ванчинхүү англи хэлнээс “Дао Дө Чин буюу жам мөрийн тухай сургаал оршивой” номыг³ хэвлүүлжээ.

Кониси Масутора,⁴ Ян Хиншун,⁵ А.А.Маслов⁶ нарын орос хэлээр хэвлүүлсэн Лаозын “Дао дэ зин” буюу “Зам мөр ба сайн үйл” хэмээх шаштирын орчуулга, тайлбарыг монгол хэлнээ хөрвүүлж “Лаозын гүн ухаан”⁷ гэсэн ном хэвлүүлсэн. Энэ нь эртний хятад хэл дээрх бүтээлийг орос хэлээр орчуулсан хувилбарыг харьцуулахад дөхөм болж буй. Лаозын зохиолыг Б.Даш-Ёндон “Зам мөр ба сайн үйл”, М.Чимэдцээ “Жам ёсны судар” гэж оноон буулгажээ. Харин Ү.Нямдорж гуай орчуулаагүй байна. Киото Их сургуулийн утга зохиолын профессор Кониси Масутора (1862-1940) анх оросоор орчуулж, 1894 онд нэрт зохиолч Лев Толстой редакторлан хэвлүүлсэн байна.

2004 онд Ч.Нарантуяа Өвөр Монголын Хишигтний Ролгаржав, Хорчины Хэшингэ, Түмэдийн Рашсэнгэ нарын орчуулж, хянасан “Шударга ном”, “Ачлалт ном”⁸ хэмээх хоёр бичгийг хөрвүүлэн хэвлүүлсэн.

Ардын Их сургуулийн Философийн факультетийн профессор Ан Цинянийн “Вопросы философии” сэтгүүлийн 2008 оны №9-д хэвлүүлсэн “Зөвлөлтийн философийг хятад эрдэмтэн үзэхүй нь” гэсэн өгүүллийг Б.Даш-Ёндон орчуулжээ.⁹ Энд зохиогч “Хятадад шинжлэх ухааны рациональч чанарыг дэлгэрүүлэхэд зөвлөлтийн философи, диалектикч агаад түүхийн материализм хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн, хэрэв диалектикч ба түүхийн материализм байгаагүй бол Хятад өнөөдрийн хөгжилд хүрч чадахгүй байсан” гэж онцолжээ. Хятадад марксизмаар

1 Конфуций. Суждения и беседы. Пер. с кит. Попов П.С. М.; Азбука-Аттикус., 2011., Примечания на второй выпуск китайской хрестоматии. Перевод и толковании Лунь-юй. 1884. Үүнийг П.С.Поповынхтой хамтатган олон удаа хэвлэжээ.

2 Орчлонг танихуйн гэгээн шастир /Бумбын сургаал/. Орч. Наранжаргал Д. Ред. Сүрэнжав Ш. УБ., 2004. 14 дэх тал.

3 Дао Дө Чин буюу жам мөрийн тухай сургаал оршивой. Орч. Ванчинхүү Ж. УБ., 2005.

4 Лао-Цзы. Дао дэ цзин. Книга пути и достоинства. Пер. Конисси Масутора. М.; Центрполиграф, 2013.

5 Ян Хин-шун. Древнекитайский философ Лао-Цзы и его учение. М.; Азбука, 1999.

6 Маслов А.А. Загадки, тайны и коды “Дао дэ цзина”. Ростов-на-Дону.; Феникс., 2005.

7 Лаозын гүн ухаан /эх сурвалж, тайлбар/. Орч. Даш-Ёндон Б. Ред. Чулуунбаатар Г. УБ., 2014.

8 Нарантуяа Ч. Күнз. Ачлалт ном, Шударга ном. УБ., 2004. 5 дахь тал.

9 *Ань Цинянь. Зөвлөлтийн философийг хятад эрдэмтэн үзэхүй нь.* //Философи, эрхийн судлал. Боть 34. УБ., 2019. 263-283 дахь тал.

дамжуулан өрнийн философиог судлах болсон юм.

Хятадын судлаачид монголчуудын философи сэтгэлгээний түүхийн талаар Өвөр Монголын эрдэмтдийн бүтээлээр дамжуулан үзэж буй, харин философийн сургалт, судалгааны өнөөгийн байдлын талаар хятад хэл дээрх мэдээлэл хомс байдаг. Профессор Р.Дарьхүү Шандуны Их сургуульд “Монгол дахь Хятадын философийн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” илтгэл, М.Золзаяа Дэлхийн философийн Их хуралд “Монгол дахь дорно, өрнийн философийн судалгааны тойм”¹ нэртэй илтгэл тус тус хэлэлцүүлсэн бөгөөд цаашид бие даасан бүтээл гаргах шаардлагатай байна.

Илтгэгчийн зүгээс *Хятадын философиог судлах арга зүйн* талаар зарим саналыг дэвшүүлж байна. Манай философийн багш нар Хятадын философиог орос хэлээр дамжуулан судалсан байдаг. Энэ үүднээс байж болох зарим учир дутагдал илэрч байгааг анхаарах хэрэгтэй байна. Жишээ нь, хүний нэрийн галигийг зөрүүтэй (Шүнз 荀子 (316-245) ба Сүнз-孙子 (544-496) эндүүрэл) бичсэн. Күнзийн зарим сургаал хятад эх зохиолоос утга санаа зөрсөн зүйл цөөнгүй байгааг нягтлаагүй хэрэглэсэн тал байна. Нэр томьёог жигдлэхэд нэмрийг бодож англи-хятад-орос-монгол философийн 2000 гаруй нэр томьёоны хадмал толь² хэвлүүлсэн анхны оролдлого, үүнд цөөн ташаарал буй.

Дэлхийн философичдын дунд Хятадын философиог өрнийн уламжлалтай философи мэдлэгийн тогтолцоо, арга зүйн зарчмаар судлан хүн, ёс суртахуун, улс төрийн тухай сургаалын түвшинд тодорхойлдог хандлага байсаар ирсэн. Докторант Э.Хулан “Өнөөдөр Хятадад “Хятадын философи”-ийг батлах хийгээд үгүйсгэх хоёр янзын хандлага зэрэгцэн оршиж буй хэдий ч, түүнийг философийн нэг төрөл хэлбэр мөн хэмээн үзэх хандлага нь илүү давамгайлж байна”³ хэмээсэнтэй санал нэг байна. Чухам ийм маргаан, мэтгэлцээний явцад Хятадад эртний Грекийн болон өрнийн философийн зарим төлөөлөгчийн үзэл баримтлалтай харьцуулан тайлбарлах, өрнийн философи арга зүйгээр судлах хандлага төлөвшиж буй юм.

Оксфордын их сургуулийн профессор Жоел Каппермэн “эртний Хятадын философиог уншигчид ойлгоход төвөгтэй ч, сэтгэл татам тал нь ер азийн философийн эх зохиолууд дахь ойлголтыг өрнийнхтэй паралель харахад хүргэдэг. Жишээ нь, Күнз, Мэнзийн зохиолд XVIII зууны Шотландын философич Д.Юмийн үзэл санаатай адил зүйлс бий. Өрнийн философитой тэнцвэртэй паралель авч үзэх нь азийн философиог улам сонирхолтой болгоно. Азийн философиог өрнийн философийн хэв загварт тохируулж тааруулах гэдэг бол бүдүүлэг мушгин

1 Zolzaya M. 蒙古国东西哲学研究概况. The XXIV World Congress of Philosophy. Learning to be Human. August 13-20, Beijing, China.

2 A Dictionary of philosophical terms. English-Chinese-Russian-Mongolian. Compiled Zolzaya M., Soyolmaa S. Ed. by Dashpurev D., Irina S. Urbanaeva., Xiong Minghui, Wulijii T. Ulaanbaatar, Soyombo print, 2018.

3 Хулан Э. Үл эцэслэгдэх маргаан: Хятадын философи “философи” мөн үү. //Философи, эрхийн судлал. Боть 35. УБ., 2019.

гуйвуулалт юм”¹ гэж дүгнэсэнд талтай хандахаас аргагүй юм. ФНОУХ-ы (FISP) ерөнхийлөгч асан феноменологич Дермот Моран “Эртний Хятадын сэтгэлгээнд танин мэдэхүй, ёс суртахууны онол гэх мэт зүйлүүд байдаг нь философи сэтгэлгээ юм. Хятадад үзэл сургаалын олон янзын уламжлал байдаг ч Хятадын философийн хүрээнд Күнзийн сургаал, даосизм, буддизм, хожмын марксизмын уламжлалыг багтааж ойлгоно. XVI зуунд Италийн Маттео Риччи Хятадад очиж Аристотелийн бүтээлийг хятад хэлээр орчуулсан үеэс тэд барууны философийг мэдэж эхэлсэн. Мөн Грекийн идеализмаас уламжлалтай Гегелийн философийг Маркс баримталж байсан. Иймээс Хятадын философи нь зарим талаараа баруунчлагдсан байдаг”² хэмээн нэгэн ярилцлагадаа өгүүлжээ.

Манайд Хятадад философийн орчин үеийн хөгжил, хандлагын талаарх судалгаа хомс, эртний Хятадын философи болон марксист философийн судалгаа, сурталчилгаанд төвлөрч, өрнийн философийн судалгааг орхигдуулсан гэж үздэг хандлага байна. Харин ч философийн түүхийн, марксизмын бүтээлээс гадна философийн онолын судалгааны бүтээл олноор хэвлэгдэх боллоо. Жишээ нь, Олон улсын метафизикийн холбооны дарга, ИР-ийн академич, Зүүн Хятадын Багшийн их сургуулийн профессор Ян Гуо Рон “Тусгайн метафизик”, “Ёс суртахууны онол”, “Ёс зүй ба оршихуй”, “Өөрийгөө болон юмыг авч үзэхүй”, “Хүн төрөлхтний үйл ажиллагаа ба практик мэдлэг” зэрэг бүтээл туурвисан. Тэрээр “Хятадын философи дахь “үйл ажиллагаа” нь өдөр тутмын дадал, ёс суртахууны практиктай илүү холбоотой бөгөөд ёс зүйн утгыг илэрхийлдэг. Марксизм нийгмийн практикт илүү их анхаарал хандуулдаг. Өргөн утгаараа “юм” нь дээрх хоёр талыг нэгэн зэрэг агуулдаг бөгөөд хүний оршихуйг бэлгэддэг. Р.Декарт: **Би сэтгэж байна тиймээс оршиж байна** гэсэн. Иймээс “юм” нь “Би үйлдэж байгаа учраас оршин байна” гэдэг утгатай. Аливаа юмыг хийх нь харилцаа бөгөөд энэ нь хүн хооронд харилцааг агуулдаг. Иймд “юм” нь хүний оршихуйд анхдагч утгатай байдаг”³ зэргээр бичсэн байна. Энэ мэтчилэн өнөөгийн философичдын бүтээлийн агуулга, арга зүйг судалгаандаа харгалзах хэрэгтэй.

Хятадын философийн судалгаа, Хятад дахь философийн судалгаа ялгаатай ойлголт. Хэрэв Хятад дахь өрнийн философийн судалгааг авч үзвэл, анхдагч эх сурвалжтай нь харьцуулан тодруулбаас нэн сайн болно. Цаашид Хятадын философийн хүлээлт бол дэлхийн философийн тогтолцоонд байр сууриа бататгахын тулд өөрийн онцлогоо хадгалан өрнийн философийн янз бүрийн чиглэлээр судлан хүрээгээ тэлэхэд чиглэж байна.

Дэлхийн философийн Их хуралд судлаачид Хятадын бизнесийн философи, Компанийн менежмент ба Күнзийн сургаал, Хятадын философи ба эмэгтэйчүүд, хүйсийн асуудал, конфуцианизм ба тогтвортой хөгжил, квант механик ба

1 Joel Kupperman. Classic Asian Philosophy. A Guide to the Essential Texts. Oxford University Press, 2007. p.IX.

2 第24届世界哲学大会主席Moran接受本号专访. -<https://mp.weixin.qq.com>. 2018.08.12.

3 杨国荣: 从“道”到“事”, 中国哲学可以为世界哲学提供资源 (转载) -<https://mp.weixin.qq.com/s/Nlnto0cmSNu6dM3F7cu8WQ>. 2020.12.20.

харьцангуй онтологийн хувьсал зэрэг философийн янз бүрийн сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.

Миний ажиглалтаар хөрш орны эрдэмтэд философийн судалгааны арга зүй, хандлагадаа эрс өөрчлөлт хийхэд нөлөөлсөн зүйлс бол: 1. Тэргүүлэх их сургуулиудын философийн тэнхим, хүрээлэнгүүдийн санаачилга. Жишээ нь, 2019 онд Бээжин их сургуульд “Философи ба хүн төрөлхтний ирээдүй судлалын төв”-ийг байгуулсан. 2. Гадаад хамтын ажиллагааг идэвхжүүлсэн. Барууны тэргүүлэх эрдэмтдийн лекц, сургалтыг тогтмол өргөн зохион байгуулдаг. 3. Гадаад, дотоодод латин, грек, герман, англи, франц хэлтэй мэргэжилтнүүд бэлтгэж байна. 4. Судалгааны тэргүүлэх чиглэлийг зөв оновчтой томъёолж, хөгжлийн чиг хандлагатай уялдуулсан төслүүдийг хэрэгжүүлдэг. Жишээ нь, хиймэл оюун ухааны хэллэгийн логик, хиймэл оюун ухааны ёс зүй, феноменологи философи, математикийн философи, аргументацийн онол, шинжлэх ухааны философи гэх мэт болно.

Хятадын философич, нийгэм судлаач эрдэмтдийн бүтээлд өнөөгийн хөгжлийн үнэт зүйлийн үзэл баримтлалыг эртний үеийн философичдын үзэл санаанд суурилсан болохыг өргөн сурталчилж байна.¹ Энэ нь Хятадын философийг сурталчлахаас илүү соёл, сэтгэлгээний уламжлалаа хадгалахын зэрэгцээ шинэчлэн баяжуулж хөгжихийн үнэ цэнийг тодруулж буй юм.

Дэлхийн нэртэй философич ОУФНХ-ы тэргүүлэгч гишүүн, Америкийн Хүмүүнлэгийн ба ШУА-ийн гишүүн, Бээжин Их сургуулийн профессор Тү Вэймин “Бидний сэтгэлгээ дэлхий ертөнцтэй хөл нийлэх ёстой бөгөөд энэ нь Хятадын соёл иргэншлийн онцлог юм. Хятадын соёл олон янз боловч нийтлэг үнэт зүйлтэй. Хятадын соёл, иргэншилд огторгуй, тэнгэр, газрын хэмжээс байсаар ирсэн. Тиймээс үндэсний ашиг сонирхлыг хэрэгжүүлэх нь энэ дэлхий ба орчлон ертөнцийн хувьд адил юм. Хятадын онцлогтой социализмын замнал нь бусад улс оронд хор хөнөөлгүй болохыг олон улсын хэмжээнд итгүүлж, энэ итгэлийн хүчийг харуулах хэрэгтэй. Дотооддоо янз бүрийн салбарт улс төрийн манлайлал нь итгэл үнэмшлээ тунхаглах ёстой”² хэмээжээ.

Фрэнсис Фукуяма “Боловсролыг дээдлэх явдлыг Япон, Хятад, Солонгосын соёл адилхан чухалчилдаг. Өнөөдрийн технологижсон ертөнцөд мэргэжлийн ур чадвар, боловсролын өгөөж асар их нэмэгджээ”³ хэмээсэн лүгээ адил, Хятадын философийн судалгаа нь дорнын соёл, иргэншлийн харилцан нөлөөлөл, зохицол, адилсал хийгээд зөрчлийн уг сурвалжийг тодорхойлох, улмаар COVID-19-ийн дараах ертөнцөд улс төр, соёл, эдийн засгийн харилцааны хамтын ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд санаа сэдэл, арга зүйн ач холбогдолтой юм.

Монголд Хятадын философи судлагдсан байдлын тоймыг энэ илтгэлд дурдсан ном, бүтээлээр хязгаарлахгүй нь лавтай юм.

1 Han Zhen and Zhang Weiwen. China's Values. 北京: 中国社会科学出版社., 2018.

2 地方性知识的儒学如何具有全球意义- <https://mp.weixin.qq.com>. 2018.08.13.

3 Фрэнсис Фукуяма. Итгэлцэл. II боть. УБ.,1995. 451 дэх тал.

***Abstract:** We are trying to define study condition on the Chinese philosophy in Mongolia and how to regard it's methodological problems in future. And we consider translation of ancient classic text, textbooks and academic papers and articles on the Chinese philosophy.*

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Академич Н.Ишжамцын бүтээл туурвил. Тэргүүн дэвтэр. УБ., 2010.
- Дашжамц Д. Монголын ард түмний ёс суртахууны дэвшилт өв уламжлалаас. УБ., 1968.
- Дарьхүү Р., Эрдэнэбаяр Г. Философийн түүх. 4 дэх хэвлэл. Ред. Лодой Г. нар. УБ., 2016.
- Зэнз. Их суртахуй. Хятад хэлнээс орчуулсан Чимидцээ М. УБ., 2008.
- Зы Си. Хэв дундын ёсон. Хятад хэлнээс орчуулсан Чимидцээ М. УБ., 2013.
- Инжиннаши В. Хөх судар. I боть. УБ., 2009.
- Күнз. Шүүмжлэл өгүүлэл. Хятад хэлнээс орчуулсан Чимидцээ М. УБ., 2004.
- Күнз. Лунь-Юй буюу бодрол агаад яриа. Эх сурвалж, тайлбар, хавсралтыг орос хэлнээс орчуулж, өмнөх үг, оршил бичсэн Даш-Ёндон Б. Ред. Дарьхүү Р., Чулуунбаатар Г. УБ., 2014.
- Лаоз. Орчлонг танихуйн гэгээн шастир. Хятад хэлнээс орчуулсан Наранжаргал Д. УБ., 2004.
- Лаоз-ын гүн ухаан (эх сурвалж, тайлбар). (Кониса Масуторо, Ян Хин-Шун нарын бүтээлийг орос хэлнээс орчуулж, оршил бичсэн Даш-Ёндон Б.). Ред. Дарьхүү Р., Чулуунбаатар Г. УБ., 2015.
- Лувсанбалдан Х. Ачлалт номын тухай. *Studia Mongolica*. Tomus III. УБ., 1961.
- Лувсанцэрэн Г. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас. УБ., 2008.
- Норовсамбуу С. Мао Цзе-Дун бол марксизм, ленинизмийг хятадын хувьсгал ба социалист байгуулалтад бүтээлчээр холбон хөгжүүлэгч мөн. Ред. Далай Ч. УБ., 1959.
- Цэнд-Аюуш Г. Улс төрийн ухамсар: түүхэн судалгаа. УБ., 2012.
- Чимэдцээ М. Бидний мэдэх хийгээд эс мэдэх Хятад орон: сэтгэлгээ соёл. УБ., 2012.
- Фрэнсис Фукуяма. Итгэлцэл. II боть. УБ., 1995

Философи, шашин судлал. МУИС.

Философи, эрхийн судлал. Боть 14. Хэвлэгдээгүй эх. 1990 он. –ШУА-ийн Философийн хүрээлэнгийн номын сан.

Философи, эрхийн судлал. Боть 34. УБ., 2019.

Фэн Ю-Лань. Хятадын философийн товч түүх. Орч. Нямдорж Ү. Ред. Дарьхүү Р. УБ., 1998.

Дорно дахины гүн ухааны сэтгэлгээ ба орчин үе. Эрдэм шинжилгээний бичиг. Дорно дахины гүн ухааны дээд сургууль. УБ., 1999.

1990-ээд оноос хойших Монголын философийн амьдрал. Эмх. Гомбосүрэн Ц. УБ., 2019.

A Dictionary of philosophical terms. English-Chinese-Russian-Mongolian. Compiled Zolzaya M., Soyolmaa S. Ed. by Dashpurev D., Irina S. Urbanaeva., Xiong Minghui, Wulijii T. Ulaanbaatar, Soyombo print, 2018.

Han Zhen and Zhang Weiwen. China`s Values. 北京： 中国社会科学出版社., 2018.

Joel Kupperman. Classic Asian Philosophy. A Guide to the Essential Texts. Oxford University Press, 2007.

The XXIV World Congress of Philosophy. Learning to be Human. August 13-20, Beijing, China. Congress Textbook.

Wang Meng. The Chinese way of thinking. Beijing, Foreign Languages Press., 2018.